

REACH

Small and Medium Enterprise Access to Credit

REACH САР ТУТМЫН СОНИН

2017 оны 03 сар №11

ЭНЭ УДААГИЙН ДУГААРТ:

1. “Бизнесийн салбарын макро орчны 2017 оны ерөнхий чиг хандлага” сэдэвт ажил хэрэгч уулзалтыг зохион байгууллаа.
2. Амжилтын Түүх
3. Зээлийн Боловсрол
4. Таны Мэдлэгт Булан
 - 4.1. Зарим бизнесийн салбарын орлогын албан татварын хэмжээ буурлаа
 - 4.2. Оюуны өмчөө барьцаалан зээл авдаг боллоо
5. Зээлийн зуучлал
6. Бизнес зөвлөгөө
7. Та хэр энтрепренёр хүн бэ?
8. REACH Төслийн 4 Сард Зохион Байгуулах Үйл Ажиллагааны Хөтөлбөр

ХОЛБОО БАРИХ:

REACH Төслийн оффис:

№ 703, МАКС Тауэр,
Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй
дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

☎ +(976) 7722-2210

✉ reach@dsmongolia.org

🌐 www.dsmongolia.org

📘 www.facebook.com/REACHProject

Баян-Өлгий Оффис:

№ 302 тоот, Гурван-Эрдэнэ Төв
5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг

☎ Утас: 7042-2080

Дорнод Оффис:

№ 11 тоот, Ольхон Худалдааны Төв,
9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг

☎ Утас: 7058-2030

Дундговь Оффис:

№ 205 тоот, Мандал Шилтгээн ХХК-ийн
байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан сум,
Дундговь аймаг

☎ Утас: 7059-2209

Сэлэнгэ Оффис:

№ 1 тоот, Алтан Булаг Төв
Сүхбаатар сум, 2-р баг, Сэлэнгэ аймаг

☎ Утас: 7036-3440

1. “БИЗНЕСИЙН САЛБАРЫН МАКРО ОРЧНЫ 2017 ОНЫ ЕРӨНХИЙ ЧИГ ХАНДЛАГА” СЭДЭВТ АЖИЛ ХЭРЭГЧ УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн зүгээс Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй REACH Төсөл болон ХасБанк “БИЗНЕСИЙН САЛБАРЫН МАКРО ОРЧНЫ 2017 ОНЫ ЕРӨНХИЙ ЧИГ ХАНДЛАГА” сэдэвт ажил хэрэгч уулзалтыг хамтран зохион байгууллаа. Тус уулзалтад, “Монгол улсын эдийн засгийн өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлага бизнест хэрхэн нөлөөлөх вэ” сэдвээр ХасБанкны ерөнхий эдийн засагч С.Болд, “2017 оны ЖДҮСангийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр”-ийн талаар ХХААХҮЯамны, ЖДҮХСангийн зээл төслийн мэргэжилтэн Ё.Соёмбо, “Дэлхийн маркетингийн чиг хандлага, маркетингийн шилдэг санаанууд” сэдвээр Vision Group-ийн ерөнхийлөгч Э.Энхбат, “ЖДБ эрхлэгчдэд зориулсан Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ, төслийн зээл” сэдвээр ХасБанкны бизнесийн банкны хэлтсийн захирал Д.Болор-Эрдэнэ нар тус тус илтгэл тавьсан бөгөөд тус уулзалтад худалдаа, үйлдвэрлэл, аялал жуучлал, барилга, тариалан гэх мэт салбаруудад үйл ажиллагаа явуулдаг 70 гаруй жижиг, дунд бизнесийн төлөөлөл оролцсон үр дүнтэй уулзалт боллоо. Энэхүү уулзалт нь Хан-Уул, Баянгол, Сүхбаатар дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулагдан зохион байгуулагдах юм.



2. АМЖИЛТЫН ТҮҮХ



Бизнесийн салбар: Модон урлал

Бизнесийн нэр: Домборын худалдаа

Бизнес эрхлэгчийн овог, нэр: Медихантын Алхам

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ихэнх жижиг, дунд бизнесүүд санхүүжилтээ банк, санхүүгийн байгууллагаас авах хүсэлтэй байдаг ч зөвхөн зээлийн бичиг баримтын бүрдүүлэлт хийхэд л маш их цаг хугацаа зарцуулдаг. Ялангуяа хөдөө орон нутгийн жижиг, дунд бизнесүүдэд зээлийн бичиг баримтын бүрдүүлэлт хийхэд мэргэжлийн зөвлөгөө дутмаг байдаг тул баримт бүрдүүлэх хугацаа нь ч удаан байдаг.

Зээлийн бичиг баримтын бүрдүүлэлт хийхэд шаардлагатай туслалцааг АНУ-ын ОУХА-ийн зүгээс Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй REACH төслөөс авах боломжтойг банкны ажилтнаас авсан М.Алхам гэх энэ залуу Монгол улсын хамгийн баруун хязгаар аймаг болох нийт хүн амын 5% болох казах үндэстнүүд олноор суурьшин амьдардаг Баян-Өлгий аймгийн домбор хийдэг залуу бизнес эрхлэгч юм. Тэрээр домбор хөгжмийн зэмсгийг үе дамжин урлагч гэр бүлд өссөн бөгөөд энэхүү авьяас чадвар нь бизнесээ эхлүүлэхэд нөлөөлжээ.

М.Алхам үйл ажиллагаа явуулдаг цэхээ шинэчлэн, ажлын байраа томсгох хүсэл эрмэлзэлтэй хэдий ч банкнаас зээл авахад шаардлагатай бичиг баримтын бүрдүүлэлт хийхэд зөвлөх, дэмжлэг туслалцаа авах шаардлага гарсан байна.

Харин REACH төсөл Баян-Өлгий салбарт хэрэгжиж, жижиг, дунд бизнесүүдэд хэрэгцээтэй зээлийн бүтээгдэхүүн авах боломжийг бүрдүүлж, зээлийн бичиг баримт бүрдүүлэхэд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж байгаа талаар сонссон тэрээр төсөлд асуудлаа шийдвэрлүүлэхээр хандсан юм.

М.Алхам хэдэн жилийн өмнө банкнаас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар зээл авахын тулд бичиг баримтын бүрдүүлэлт хийхэд нэлээдгүй хугацаа зарцуулж байсан бол харин энэ удаад зээлийн бичиг баримтыг REACH төслийн үр дүнтэй зөвлөмж мэдээллийн дагуу өдөртөө бүрдүүлж чадсан юм.

“АНУ-ын ОУХА-ийн зүгээс хэрэгжүүлж байгаа REACH төсөл зээл авахад минь тусалж, цэхээ шинэчлэн барих ажлыг маш хурдан хугацаанд хийхэд минь тусалсанд баярлаж байна.”

Түүнчлэн М.Алхам домборын төрөлжсөн дэлгүүртэй болох ирээдүйн зорилгоо биелүүлэхийн тулд авсан зээлээ үр бүтээлтэй зарцуулж, бизнесээ улам өргөжүүлэхийн тулд санхүүгийн боловсрол маш чухал гэдгийг REACH төслийн санхүү, зээлийн боловсрол олгох сургалтад хамрагдсанаар ойлгож авсан байна.

3. ЗЭЭЛИЙН БОЛОВСРОЛ

БАНК ЗЭЭЛ ОЛГОХДОО МӨНГӨН УРСГАЛЫГ ОНЦГОЙ АНХААРДАГ

Ямарч зээлийн өргөдлөөс хардаг гол асуулт бол "зээлдэгч бэлэн мөнгө бий болгох чадвартай юу?" / мөнгөн урсгалаараа зээл төлж чадах уу/ ерөнхийдөө, зээлдэгч 3 үндсэн эх үүсвэрээс л зээлээ төлдөг.

1. Борлуулалтын орлогоос орсон бэлэн мөнгө
2. Өөрийн хөрөнгөө борлуулснаас орох бэлэн мөнгө
3. Өр, зээл тавих болон, хувьцаа худалдаанд гаргаснаас орох бэлэн мөнгө. Эдгээр эх үүсвэрүүдийн аль нь зээл төлөхөд хангалттай байж болно. Гэсэн ч зээлдүүлэгч үндсэн үйл ажиллагааны бэлэн мөнгөний урсгалаас зээл төлүүлэх сонирхолтой байдаг. Учир нь хөрөнгөө борлуулснаар бизнесийн хүч суларч болох бөгөөд цаашлаад зээлийг чанарыг бууруулна. Түүнчлэн бэлэн мөнгөний дутагдал нь бизнес доройтож байгааг илэрхийлэх бөгөөд зээл асуудалд орж байгааг харуулна. Тиймээс банкны хуулиар зээлдүүлэгч зээл олгохдоо бэлэн мөнгөн урсгалд суурилахыг шаардсан байдаг.

Бэлэн мөнгөн урсгал гэж юу вэ? Нягтлан бодох бүртгэлийн хувьд дараах байдлаар тодорхойлогдоно.

Үүнийг уламжлалт бэлэн мөнгөн урсгал гэнэ. Цааш нь задалж бичвэл: Бэлэн мөнгөөр гардаггүй зардлаас бусад дээр дурдсан зүйлс нь бэлэн мөнгөн сууриар тооцогдоно.

Жишээ нь, 100 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой бизнес, 70 сая төгрөгийн ББӨ, удирдлага борлуулалтын зардал нь 15 сая, татварт 5 сая, элэгдэл болон бусад бэлэн мөнгөөр гардаггүй зардал нь 6 сая байвал төлөвлөгдсөн мөнгөн урсгал нь 16 сая болно. Зээлдүүлэгч жилийн мөнгөн урсгалын хэмжээ нь зээлийн төлбөрийг хангалттай төлж мөн цаана нь тооцоолоогүй зардлууд гарахад төлж хүрэхүйц байна уу гэдгийг тодорхойлох ёстой.



Хэрэв чи зах зээлийн ганц орноор хэмжигдэх хувийг эзэмшдэг бол том хөвгүүнтэй өрсөлдөж, ялгарах хэрэгтэй, үгүй бол сүйрэл чамайг тосно.

МАЙКАЛ ДЭЛЛ

Dell computers-ийн үндэслэгч (1965-)



Бизнесээ тогтвортой байлгах бол асар их хөлс хөдөлмөр байдаг бөгөөд өлсөж цангах бол тулааны хагас нь юм.

ВЭНДИ ТАН ВАЙТ

Их Британы бизнес эрхлэгч (1970-)

Илүү дэлгэрэнгүйгээр авч үзвэл бизнесийн байгууллагад зээл олгохдоо зээлийн эдийн засагч маш анхааралтай нягталж үздэг дараах таван үндсэн хэсгээс мөнгөн урсгал бүрдэнэ. Үүнд:

1. Борлуулалтын орлогын өөрчлөлтийн түвшин /энэ нь бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийт хүлээн зөвшөөрч, чанартай байгааг илэрхийлнэ./
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн өөрчлөлтийн түвшин /түүхий эд материалын зардал орно/
3. Борлуулалт, удирдлагын зардлын өөрчлөлтийн түвшин
4. Бэлэн мөнгөөр хийгдсэн татварын төлбөрүүд
5. Бэлэн мөнгөөр гардаггүй зардлуудын өөрчлөлтийн түвшин

Бизнес эрхлэгч таны бизнесийн эдгээр бэлэн мөнгөний эх үүсвэрүүд дэх сөрөг өөрчлөлтүүдэд эдийн засагч судалгаа хийн зээл олгох эсэх шийдвэрээ гаргадаг.

Илүү сүүлийн үеийн, мөн илүү ойлгомжтой мөнгөн урсгалыг хэмжих арга бол мөнгөн урсгалын шууд арга юм. Энэ нь энгийн хэрнээ дараах чухал зүйлд хариулт өгдөг. Яагаад бэлэн мөнгөнд өөрчлөлт орсон бэ?

Энэ арга бэлэн мөнгөний урсгалыг 3 үндсэн эх үүсвэрт хуваадаг:

- Үйл ажиллагаан цэвэр бэлэн мөнгө/ зээлдэгчийн мөнгөн сууриар илэрхийлсэн цэвэр орлого/
- Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр бэлэн мөнгө
- Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр бэлэн мөнгө /зээлдэгч хөрөнгө худалдаж авсан болон зарснаас үүссэн бэлэн мөнгөний өөрчлөлт

Мөнгөн урсгалыг үзүүлэх энэхүү арга болон энэ аргын бүрэлдэхүүн хэсгүүд нь зээлдэгчийн мөнгөн урсгалын өнөөгийн эх үүсвэр нь хаанаас байна вэ гэдгийг гаргаж ирэхэд маш чухал юм. Жишээлбэл, ихэнх зээлдүүлэгчид үйл ажиллагаанаас /бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт/ орж ирэх мөнгөн урсгалыг илүүд үздэг. Хэрвээ эсрэгээрээ орж байгаа мөнгөн урсгалын үндсэн хэсэг нь хөрөнгөө худалдсанаас эсвэл зээл авснаас бий болсон бол зээлдэгч ирээдүйд мөнгө бий болгох магадлал багатай байх ба зээл авбал зээлдэгчид эрсдэл учирна.

Эх сурвалж: <http://zeeliin-shinjilgee.blogspot.com>

4. ТАНЫ МЭДЛЭГТ БУЛАН



4.1 ЗАРИМ БИЗНЕСИЙН САЛБАРЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ БУУРЛАА

УИХ-ын 2017 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталлаа.

Хууль батлагдсанаар жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, хүнсний үйлдвэрлэл, хувцас болон нэхмэлийн үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл болон газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн үндсэн үйл ажиллагааны орлогод 1 хувиар орлогын албан татвар ногдуулахаар боллоо.

Жижиг, дунд буюу жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй аж ахуйн нэгжид 1 хувиар албан татвар ногдуулах зохицуулалтыг хийснээр аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа задлах, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх замаар энэхүү хөнгөлөлтөд өргөнөөр хамрагдах, улмаар төсвийн орлогын эх үүсвэрт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл байсан.

Иймээс албан татвар төлөгчийн тайлант жилийн албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо тухайн албан татвар төлөгч болон түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох орлогын нийлбэр дүнгээр тодорхойлохоор хуульд заасан.

Хууль батлагдсанаар эхний ээлжинд нийт 4678 жижиг дунд аж ахуйн нэгж татварын хөнгөлөлтөд хамрагдаж, 1.3 орчим тэрбум төгрөгийн татварын дэмжлэгийг эдлэхээр байна. Мөн жижиг, дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийн татварын дарамт буурч, ажлын байр, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх таатай нөхцөл бүрдэх болно. Үүгээр зогсохгүй шинээр бизнес эрхлэх явдлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт нэмж татах нөхцөл бүрдэх юм.

Эх сурвалж: www.mta.mn



Маш сайн компани төгс байдалд итгэдэггүй бөгөөд зөвхөн үргэлж сайжран боловсронгуй болох болон үргэлж өөрчлөлтөнд итгэдэг

ТОМ ПИТЕРС

АНУ-ын бизнесийн мэргэжилтэн (1942-)



4.2 ОЮУНЫ ӨМЧӨӨ БАРЬЦААЛАН ЗЭЭЛ АВДАГ БОЛЛОО

2015 оны долдугаар сард УИХ-аар батлагдсан Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус барьцааны тухай хууль ирэх гуравдугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. Нийтдээ долоон бүлэг, 59 зүйлтэй уг хуулиар барьцааны баталгаажилт, барьцаалагчийн давуу эрх, барьцааны талуудын эрх үүрэг, барьцааны эрх хэрэгжүүлэх асуудлуудыг зохицуулж өгөөд байгаа юм. Уг хууль хэрэгжиж эхэлснээр бизнес эрхлэгчид тэр дундаа жижиг дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаа, бизнесээ өргөжүүлэх боломж нээгдэх юм. Өөрөөр хэлбэл, уг хууль хэрэгжсэнээр үл хөдлөх хөрөнгийн барьцаагүйгээр бизнес төлөвлөгөө, лангуун дээрх бараа бүтээгдэхүүнээ үнэлүүлэн банкнаас зээл авах боломж нээгдэж байна.

Хөдлөх хөрөнгөд үл хөдлөхөөс бусад бүх эд хөрөнгө гэж тооцогддог. Тухайлбал, иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувьцаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь арилжааны банкны зээлийн барьцааны зүйл болно. Бизнес эрхлэгчид тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгсэл, мал, тариалангийн газартаа тариалж буй хүнсний ногоо, үр тариагаа барьцаалан банкнаас зээл авч болно.

Иргэдийн барьцаалсан хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн мэдэгдлийг бүртгэх Цахим мэдээллийн сан байгуулах юм байна. Уг Цахим сан байгуулах ажил дуусч энэ сарын 20-нд нээлтээ хийх аж.

Цахим мэдээллийн санд бүртгэсэн иргэн, аж ахуйн нэгжийн барьцааны мэдэгдлийн бүртгэлийн талаарх статистик мэдээг сар, улирал, жилээр улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх үүргийг Бүртгэлийн байгууллага хүлээж байгаа юм. Цахим мэдээллийн сан нь улсын хэмжээнд нэгдсэн, нийтэд нээлттэй байх бөгөөд интернетэд холбогддог бүх хүн цахим сангаас мэдээлэл авах, хайлт хийх боломжтой юм байна.



Монгол Улсад орж ирдэг гаднын хөрөнгө оруулалтаас хоёр дахин их хөрөнгө бүртгэлгүй, эдийн засгийн эргэлтэд орж чадалгүйгээр хувь хүмүүсийн гарт байна гэсэн судалгаа 2013 онд гарч байсан. Тэгэхээр хөдлөх эд хөрөнгийг барьцаалж зээл олгох нь далд, сул байгаа хөрөнгийг ил болгоход үр дүнтэй гэж хууль санаачлагчид үзэж байгаа юм. Арилжааны банк иргэдийн өдлөх эд хөрөнгөөр барьцаалж зээл гаргаснаар зээлийн хамрах хүрээ тэлнэ. Үүнийг дагаад зээлийн хүү буурах магадлал ч бий. Зээлдэгчийн талаас үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, шинэ ажил эхлүүлэх замаар үндэсний үйлдвэрлэл сэргэх, цаашлаад бүтээн байгуулалт, худалдааны салбарт үйлдвэрлэл өсөх нөхцөл бүрдэх аж.

Эх сурвалж: <http://www.itoim.mn/>

Хэрэв та үйл ажиллагаагаа ямар дарааллаар хийж байгаагаа тодорхойлж чадахгүй бол та юу хийж байгаагаа ч мэдэхгүй.

В.ЭДВАРД ДЕМИНГ

5. ЗЭЭЛИЙН ЗУУЧЛАЛ

ЗЭЭЛИЙН ҮЕ ШАТ

Зээл хүсэгчийн зан төлөв, зорилгыг үнэлэх:

Хэрэв бизнес эрхлэгч та зээл авахаар банкруу хандсан бол банкны зүгээс хамгийн түрүүнд таны зээлийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ярилцлага хийдэг. Энэ ярилцлага зээлийн мэргэжилтэнд зээлдэгчийн зан төлөв, зорилгыг тодорхойлох боломж олгодог гадна цаашид зээлийн гүнзгийрүүлсэн судалгаа хийх шаардлагатай эсэхийг тодорхойлоход ашиглагддаг. Банкны зүгээс зээл олгохдоо дараах зүйлсийг чухалчлан үздэг: Бизнесийн бүтэц зохион байгуулалт, иргэн, хуулийн этгээдийн тухайн төслийг хэрэгжүүлж чадах туршлага, удирдлагын чадвар, мэдлэг, нийт ажиллагсад, санхүүгийн хариуцлага, хууль дүрмийн мөрдөлт, өмнөх зээлийн түүх, хувь хүн болон компанийн нэр хүнд, гуравдагч этгээдээс авсан зэрэг сөрөг мэдээлэл зэрэг багтдаг. Мөн зээл хүсэгч та өөрийн зээл авах зорилгоо тодорхой бус, ойлгомжгүй илэрхийлэх, зээлийн нөхцлийг биелүүлнэ гэдгээ илэрхийлэхдээ өөртөө итгэлгүй байвал энэ нь зээл олгохоос татгалзах том шалтгаан болж байдаг.

Зээл хүсэгчийн зээлийн түүхийг судалж, газар дээр очиж үзэх:

Хэрвээ та бизнесийн зээл хүсч байгаа бол зээлийн мэргэжилтэн харилцагчийн байгаа газарт нь очиж хөрөнгийн байрлал болон нөхцөл байдалд үнэлэлт өгч, тодруулах асуултууд асууна. Үг судалгаагаар зээл хүсэгчийн анхны ярилцлагаар өгсөн мэдээлэл, бүрдүүлсэн баримт материалууд Зээлийн мэргэжилтэн өмнө нь зээл олгож байсан бусад зээлдүүлэгч руу холбоо барьж харилцагчийн талаар лавлаж болно. Хэрэв та өмнө зээл авч байсан бол таны өмнөх зээлийн гэрээгээ бүрэн дүүрэн биелүүлсэн эсэхийг харах бөгөөд энэ нь зээлдэгчийн зан төлөв, үнэнч байдал, хариуцлагатай байдлыг илүүтэй харуулж байдаг.

Зээл хүсэгчийн санхүүгийн байдалд үнэлэлт өгөх:

Бүх зүйл нь хангалттай байвал банк тухайн зээлдүүлэгчээс зээлийн хэлэлцээр хийхийг зөвшөөрсөн захирлуудын зөвлөлийн шийдвэр, санхүүгийн бүрэн тайлан гэх мэт зээлийн хүсэлтийг үнэлэхэд шаардагдах хэд хэдэн чухал баримт бичгүүдийг гаргуулж авна.

Зээлийн хувийн хэрэг бүрдмэгц зээлийн шинжилгээний хэлтсийнхэн харилцагчийн санхүүгийн бүрэн шинжилгээг хийн харилцагч зээл төлөхөд хүрэлцээтэй бэлэн мөнгөний урсгал болон барьцаа хөрөнгө байгаа эсэхийг тодорхойлохыг зорино.

Зээл хүсэгчийн санхүүгийн байдалд үнэлэлт өгөх:

Бүх зүйл нь хангалттай байвал зээл хүсэгчээс тухайн зээлдүүлэгчээс зээлийн хэлэлцээр хийхийг зөвшөөрсөн захирлуудын зөвлөлийн шийдвэр, санхүүгийн бүрэн тайлан гэх мэт зээлийн хүсэлтийг үнэлэхэд шаардагдах хэд хэдэн чухал баримт бичгүүдийг харилцагчаас гаргуулж авна. Зээлийн хувийн хэрэг бүрдмэгц зээлийн шинжилгээний хэлтсийнхэн харилцагчийн санхүүгийн бүрэн шинжилгээг хийн харилцагч зээл төлөхөд хүрэлцээтэй бэлэн мөнгөний урсгал болон барьцаа хөрөнгө байгаа эсэхийг тодорхойлохыг зорино.

Зээлийн шинжилгээний хэлтсийнхэн товч дүгнэлт болон зээлийн саналыг бэлдэн холбогдох зээлийн хороо руу явуулах бөгөөд том зээлийн хувьд зээлийн шинжилгээний хэлтсийн гишүүд биер оролцож илтгэлээ тавин, зээлийн хүсэлтийн сул болон давуу талуудыг зээлийн хорооныхонтой хэлэлцэнэ.

Боломжит зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэн, зээлийн гэрээнд гарын үсэг зурах:

Зээлийн хүсэлтийг зээлийн хороо баталвал зээлийн мэргэжилтэн болон зээлийн хорооныхон хэрвээ зээл эргэн төлөгдөж чадахгүйд хүрвэл барьцаа болох хөрөнгийн очиж шалгана. Үүнийг зээлийн барьцаа хөрөнгийг шаардах эрхийг баталгаажуулалт гэж нэрлэдэг байна. Зээлийн хороо болон зээлийн мэргэжилтэн зээл болон зээлийн барьцаа хөрөнгөнд сэтгэл хангалуун байвал зээлийн гэрээ байгуулахад холбогдох бичиг баримтуудыг бэлдэх бөгөөд гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулна.

Зээлийн гэрээний хэрэгжилтийг хянах, харилцагчийн бусад хэрэгцээ шаардлагууд:

Зээл олгосны дараа банкны зүгээс батлагдсан шинэ гэрээний нөхцөлийг биелүүлж байгаа эсэхийг байнга хянаж байх ба зээлийн үндсэн төлбөр болон хүү хугацаандаа төлөгдөж байгаа эсэхийг шалгаж байдаг. Том зээлийн хувьд зээлийн мэргэжилтэн харилцагчийн бизнес дээр давтамжтайгаар очиж харилцагчийн үйл ажиллагааг шалгана. Хэрэв таны бизнесийн үйл ажиллагаанд доголдол гарах эсвэл нэмэлт санхүүжилт шаардлагатай болвол өөрийн харилцагч зээлийн мэргэжилтэнд заавал дуулгах шаардлагатай бөгөөд мэдэгдэлгүйгээр дахин зээл авах нь өөрийн бизнест учирах эрсдлийн хэмжээг нэмэгдүүлж улмаар зээлээ төлж чадахгүй байх нөхцөл байдлыг үүсгэж байдаг.

Эх сурвалж: <http://zeeliin-shinijilgee.blogspot.com>

6. БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНДАА ГАРГАДАГ **АЛДАА**



АЛДАА-1:

Тайлангаа зөв хүнээр гаргуулж байна уу?

Жижиг дунд аж ахуйн нэгжүүд ихэвчлэн орон тооны нягтлангүй, гэрээт хүнээр, эсвэл хүн хүнээр тайлангаа гаргуулдаг. Дараа нь тухайн байгууллагад татварын шалгалт ороод яаж тайлан гаргасан бэ? гэж асуухад нөгөө нягтлан нь алга болчихдог, эсвэл тодорхой хариулт байдаггүй. Нягтлангийн буруугаас болж бий болсон татварын актыг байгууллагын удирдлага л төлөх болж таардаг.

АЛДАА-2:

Баримт бүрдүүлэлт дээр асуудалгүй биз?

Орон тооны нягтлангүй байгууллагуудын захирал нь ихэвчлэн өөрөө касса барьдаг, тооцоогоо зүгээр л нэг дэвтэр дээр хөтлөөд явдаг. Гэтэл тухайн байгууллагад гарсан ажил гүйлгээ бүр анхан шатны баримтаар баталгаажсан байх ёстой. Эдгээр баримтуудыг бүрдүүлээгүй бол таны санхүүгийн тайлан хэдий зөв хийгдсэн байлаа ч хүчин төгөлдөр болж чадахгүй. Ингээд тухайн байгууллагад их хэмжээний татварын акт тогтоолгох тохиолдол бий.

АЛДАА-3:

Татвараа хугацаанд нь төлсөн үү?

Татварын ерөнхий хуулийн 74.2-т зааснаар татварыг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын дүнд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн торгууль ногдуулна. Жишээнь: НӨАТ-аар 1,000,000 төгрөгийг төлөхөөр ногдол гарсныг дараа сарын 25-нд төлсөн гэвэл хугацаа хэтэрсэн 15 хоногт ногдох татварын акт нь / 1000000 төг * 15 хоног * 0.1 хувийн торгууль / 15000 төгрөгийн торгууль ногдож байна. Энэ нь хугацаандаа татвараа төлөөгүйгээс гарч байгаа үргүй зардал юм.

ДҮГНЭЛТ:

1. Ихэнх байгууллагууд татварын шалгалтаар орж акт тавиулсны дараа л би буруу явж байсан юм байна гэдгээ ойлгодог. Тиймээс таныг дээрх эрсдлүүдээс сэргийлэхийг урьдчилан анхааруулж байна.
2. Хэрэв дээрх эрсдэлүүд бий болбол татварт ямар хэмжээний торгууль төлдгийг мэддэг байх шаардлагатай.
3. Иймд та аль болох мэргэжлийн байгууллагаар тайлангаа гаргуулбал эргээд буух эзэнтэй.
4. Эсвэл сайн нягтлантай байх шаардлагатай. Сайн нягтлантай байх эсэх нь байгууллагын удирдлагаас ихэнхдээ шалтгаалдаг.

Эх сурвалж: <http://sankhuugiinbolovsrol.mn>



7. СОНЖОО: ТА ХЭР ЭНТРЕПРЕНЁР ХҮН БЭ?

Шинж чанарууд	Тайлбар	Үнэлгээ									
1 Хандлага	Сэдэлжилт өндөртэй	1	2	3	4	5	6	7	8	9	10
2 Шаргуу байдал	Зорилгынхоо төлөө цуцалтгүй тэмцэж чаддаг	1	2	3	4	5	6	7	8	9	10
3 Эрсдэл	Эрсдлийг боломж болгох чадвар	1	2	3	4	5	6	7	8	9	10
4 Зохион байгуулалттай байдал	Ажил, амьдралаа салгаж чаддаг	1	2	3	4	5	6	7	8	9	10
5 Итгэлтэй байдал	Өөрөө өөртөө итгэх чадвар	1	2	3	4	5	6	7	8	9	10
6 Ятгах чадвар	Бусдыг итгүүлэх чадвар	1	2	3	4	5	6	7	8	9	10
7 Шударга байдал	Нээлттэй, итгэл даах чадвар	1	2	3	4	5	6	7	8	9	10
8 Өрсөлдөх чадвар	Ялах хүсэлтэй	1	2	3	4	5	6	7	8	9	10
9 Дасан зохицох чадвар	Шинэ нөхцөлд хурдан дасан зохицож чаддаг	1	2	3	4	5	6	7	8	9	10
10 Ойлгох чадвар	Бусдыг ойлгох чадвар	1	2	3	4	5	6	7	8	9	10
11 Сахилга бат	Өөрийгөө хянах чадвар	1	2	3	4	5	6	7	8	9	10
12 Алсын хараа	Зорилгодоо үнэнч байдал	1	2	3	4	5	6	7	8	9	10

Тайлбар: Таны авсан оноо таны энтрепренёр шинж чанарыг илэрхийлнэ. Хэрэв та дунд болон дундаас бага оноо авбал эдгээр өгөгдсөн шинж чанарууд дээр төвлөрч өөрийн ур чадваруудаа хөгжүүлээрэй.

Энтрепренёр гэж хэн бэ?

20-р зууны агуу сэтгэгчид тэгвэл уг нэр томъёог дараах байдлаар тодорхойлсон байна. Австрийн нэрт эдийн засагч, суут сэтгэгч Шумптер ийнхүү тодорхойлжээ: “Одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаа байдлыг эвдэх замаар шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгодог шинийг санаачлагчийг энтрепренер гэнэ.” Даллас Маверикс багийн эзэн, хөрөнгө оруулагч Марк

Кюбан: Ямар бизнес хийхээ, хаана хүрэхээ, тийшээ хэрхэн хүрэхээ тодорхойлж чадах хүнийг энтрепренер гэнэ. Дэлхийн хамгийн том санхүүгийн хэвлэл мэдээллийн байгууллагыг үндэслэгч Майкл Блүүмберг: Энтрепренер байна гэдэг нь заавал бизнес эхлүүлэхийн нэр биш. Энэ нь бусдын бэрхшээл гэж харж буйг боломж болгон хувиргаж, тэдний тойрч буй эрсдэлийг үүрч гарахын нэр юм.

8. REACH ТӨСЛИЙН 4 САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Улаанбаатар салбарт:

- 2017.04.25-27 “Бизнес Төсөл Боловсруулах Аргачлал”, “Санхүүгийн Тайланг Уншиж ойлгох нь”, “Санхүүгийн Тайлангийн Шинжилгээ ба Хэрэглээ”, “Зээлийн Боловсрол” сэдвээр сургалт
- 2017.04.19 “Хасбанкны харилцагчдад зориулсан уулзалт”

Орон нутгийн салбаруудад:

- 2017.04.17 Сэлэнгэ салбарт “Нягтлан бодох бүртгэл” сэдвээр сургалт
- 2017.04.07 Баян-Өлгий салбарт “Бизнес төсөл боловсруулах ур чадвар олгох нь” сэдвээр сургалт
- 2017.04.12 Дундговь салбарт, “Бизнес төсөл боловсруулах ур чадвар олгох нь” сэдвээр сургалт
- 2017.04.20 Дундговь салбарт “Дундговь аймгийн статистикийн газартай хамтарсан ажил хэрэгч уулзалт”
- 2017.04.25 Дорнод салбарт “Бизнесийн байгууллагын ажилчдын харилцаа хандлага түүнийг идэвхижүүлэх арга замууд” уулзалт
- 2017.04.21 Дорнод салбарт “Бизнес төсөл боловсруулах ур чадвар олгох - Байгаль орчныг хамгаалах төслийг хэрэгжүүлэгч нар зориулсан сургалт

Та дээрх сургалт, уулзалтанд бүртгүүлэх бол:

- **Улаанбаатар Оффис:**
№: 703, МАКС Тауэр, Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот,
Утас: 7722-2210,
И-мэйл: reach@dsmongolia.org
- **Баян-Өлгий Салбар**
№ 302 тоот, Гурван-Эрдэнэ Төв 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг. Утас 7042-2080
- **Дундговь Салбар**
№ 205 тоот Мандал Шилтгээн ХХК-ийн байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан Сум, Дундговь аймаг. Утас 7059-2209
- **Дорнод Салбар**
№11 тоот, Ольхон Худалдааны Төв, 9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг. Утас 7058-2030
- **Сэлэнгэ Салбар**
№1 тоот, Алтан Булаг Төв, Сүхбаатар сум, 2-р Сэлэнгэ аймаг. Утас 7036-3440

“Энэхүү сонинг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр дэмжлэгтэйгээр бүтээсэн болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь сонинтой холбоотой хариуцлагыг бүрэн хүлээх бөгөөд үүнд АНУ-ын Засгийн Газар болон АНУ-ын ОУХА-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.”